



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР**

2018 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 03

Өлгий

**Хичээлийн жилийн үлдсэн болон ойрын хугацаанд
анхаарах зарим зүйлийн тухай**

2017-2018 оны хичээлийн жилийн үлдэж буй хугацаанд анхаарч ажиллах зарим зүйлийн талаар дараах албан даалгаврыг хүргүүлж байна.

1.Хичээл сургалтын үйл ажиллагааны чанар, өгөөжийг сайжруулан, төгсөлтийн болон анги дэвших шалгалтаа суралцагч өөрийн сурсан эрдэм, авьяасаа тайлагнах, боловсролын баримт бичиг гардуулах ёслол болгон тэмдэглэн өнгөрүүлэх, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт тавьж дараах зүйлийг хэрэгжүүлэх:

- Суралцагчдаас хуульд заагаагүй аливаа төлбөр, хураамж, хандив авахыг хориглох;
- Анги дэвших болон улсын шалгалт, элсэлтийн ерөнхий шалгалттай холбоотойгоор хичээл заадаг багш тухайн ордог хичээлээрээ суралцагчдад төлбөртэй давтлага өгөх, ном, гарын авлага, материал худалдан авахыг шаардах, шахахыг хориглох;
- Сурагчдын зөвлөл, эцэг эхийн зөвлөлийн үүсгэл санаачлага нэрээр мөнгө татаж, багшид бэлэг өгөх, эцэг эхэд санхүүгийн дарамт учруулахыг таслан зогсоох;
- Хөдөө хээр, амралт зуслан, голын сав, жуулчны бааз, зочид буудал, цэнгээний газруудад амралт, зугаалга зохион байгуулах, архи согтууруулах ундаа хэрэглүүлэхийг хориглох, хүүхдийн аюулгүй байдлыг хангах талаар онцгой анхаарч хоолны хордлого, тээврийн хэрэгслийг жолоодог осолд орохоос урьдчилан сэргийлэх;

2.2017-2018 оны хичээлийн жилд БСШУЯ, аймгийн БСУГ-аас дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг нарийвчлан гаргаж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр ирэх хичээлийн жилд дэвшүүлэх зорилтын төслийг боловсруулах

3.Анги дэвших, төгсөх болон элсэлтийн ерөнхий шалгалтын зохион байгуулалтыг хангаж, суралцагч, эцэг эх асран хамгаалагч багш нарт үнэн зөв мэдээлэл хүргэж, иргэдийг төөрөгдүүлсэн аливаа худал мэдээллээс урьдчилан сэргийлэх

00000005


4.Цэцэрлэгийн болон нэгдүгээр ангийн элсэлт, бүртгэлийг иргэдэд чирэгдэл, хүндрэлгүй зохион байгуулж, аливаа мэдээллийг нээлттэй өгөх, дотуур байранд суух 6 настангуудын ая тухтай байдлыг хангах талаар урьдчилсан бэлтгэлийг хангах

5."Тогтвортой хөгжил-Сургуулийн өмнөх боловсрол", "Тогтвортой хөгжил-Ерөнхий боловсрол" улсын нэг, хоёрдугаар зөвлөгөөнд оролцогчдоос гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, яамнаас шинээр батлагдсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх

6.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн анги танхим, дотуур байр, гуанз, ариун цэврийн байгууламж, гадна талбайн засвар, үйлчилгээг 2018 оны 6 дугаар сарын 18-гы дотор дуусгахаар зохион байгуулах, боловсролын ногоон байгууламж, орчны тохижилт, аюулгүй байдалд онцгой анхаарах

7.2018-2019 оны хичээлийн жилийн болон өвөлжилтийн бэлтгэлийг хангах төлөвлөлтийг гаргах, шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэх, хэрэгжүүлэх, хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг нарийн баримтлах

Энэхүү чиглэлийн хүрээнд авч хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Ерөнхий боловсролын бодлогын газарт хүргүүлэхийг Боловсрол, соёл, урлагийн газарт даалгаж байна.

ЗАСАГ ДАРГА  А.ГЫЛЫМХАН